



# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Д.Оюунхорол сайд ч СҮЙХЭЭТЭЙ ЮМ АА

Б.ТОГТОХ

Монгол Улс бүх нийтээр мод тарих өдөртэй болоод багагүй хугацаа өнгөрч байна. Ерөнхийлөгчийн санаачилсан энэ үйл ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж иргэн бүхний оролцдог томхон арга хэмжээ болжээ. Уламжлалт мод тарих өдөр өнгөрөгч бямба гарагт тохиож, төр засгийн өндөрлөгүүдээс эхлээд, төрийн албан хаагчид, байгууллага, иргэд хүртэл мод тарив. Тухайлбал, УИХ-ын дарга М.Энхболд, хотын захирагч Су.Батболд, БОАЖ-ийн сайд Д.Оюунхорол тэргүүтэй албаны хүмүүс Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьсан бол Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “АСЕМ вилла” цогцолборт Ардын үг уулзалтад оролцож буй иргэдтэй хамт мод тариала. Мөн Төрийн орон сууц корпораци, Баянзүрх дүүргийн иргэд гэх мэтээр аж ахуйн нэгж албан байгууллагууд ч мод тарих өдрөөр тус тусын төгөл байгуулж, мод тарив. Салбарын сайд Д.Оюунхорол энэ өдөр мод тарьж буй иргэдийн санаачилгыг дэмжиж үг хэлэхдээ “Уур амьсгалын өөрчлөлтөд өртөж байгаа манай улсын хувьд мод тарьж, ногоон байгууламжаа нэмэгдүүлэх нь нэн чухал алхам болж байгаа. Манай яамны зүгээс тарьсан мод бүрийг ургуулах талаар анхаарч холбогдох байгууллагуудтай нь хамтран бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлээд байна”

гэв. Энэ өдөр нэгэн өвөрмөц төгөл байгуулсан нь дотоодын төдийгүй, гадаадын улс орнуудын анхаарлыг эрхгүй татаж байв. Тодруулбал, Д.Оюунхорол сайдын санаачилгаар энэ өдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг бүх орны элчин сайдууд мод тарих өдөрт нэгдэж, өөрсдийн нэрэмжит төгөлтэй болсон юм. БНХАУ-ын элчин сайд манай улсын Ерөнхий сайд тус улсад айлчилж буйтай холбоотой эзгүй байсан бол БНСУ-ын элчин сайд Ерөнхийлөгчдөө баяр хүргэхээр нутаг буцсан байсан аж. Дээрх хоёр улсаас бусад бүх орны элчин сайдууд ирж мод тарьж, мөн өөрийн орны мод тарих туршлагаас хуваалцсан нь эрхгүй анхаарал татаж байсан юм. Мод тарих асуудал зөвхөн дотоодын хэдэн байгууллагын эсвэл иргэдийн сайн дурын үндсэн дээр хийх ажил биш. Уур амьсгалын өөрчлөлт дэлхий дахины санаа зовоох асуудал болсон энэ үед цолжилтгүй хамтдаа тэмцэх нь зүйтэй хэмээн элчин сайдуудыг уриалж чадсан Д.Оюунхорол сайдад талархах хүмүүс ч бишгүй олон байв. Тэдний хувьд бөөнөөрөө ийнхүү нэгдэж, нэг асуудалд анхаарлаа хандуулах нь ховорхон үзэгдэл бөгөөд энэхүү үйл ажиллагааг “Мини” АСЕМ-ын хэмжээнд үнэлж байгаага ч элчин сайдууд онцолж, эх орныхоо өмнө тулгамдаад байгаа ногоон хөгжлийн асуудалд олон улсын анхаарлыг нэгэн



зэрэг татаж, цаашид хамтарч ажиллах гарцыг олж харсан БОАЖ-ны хамт олонд баяр хүргэж, хамтарч ажиллана гэдгээ илэрхийлж байлаа. Мөн элчин сайдууд өөр өөрийн орны туршлагаас хуваалцав. Тухайлбал, Чехийн Элчин

сайд хатагтай Ивана Гроллова л гэхэд монголчуудын арга барилаас огт өөрөөр мод тарьж байсан бөгөөд тэрбээр ухсан нүхэндээ ус дүүргэсний дараа модоо суулгаж байсан нь бусад Элчин сайдад чех технологиор мод тарих хүслийг төрүүлж,

“Элчин төгөл”-ийн хэд хэдэн модыг энэ аргаар суулгаж амжлаа. Элчин сайдууд мод тарьсныхаа дараа АСЕМ виллад чуулж, уур амьсгалын өөрчлөлтөөс хэрхэн ангижрах өөрсдийнхөө туршлагаас хуваалцаж, цаашид энэ талаар Монгол Улстай хэрхэн хамтарч ажиллах талаараа Д.Оюунхорол сайдтай санал солилцсон юм. Өөр өөрийн орны элчин сайдуудын энэхүү сайн үйлсийг тухайн орны хэвлэл мэдээлэл сайшаах нь тодорхой. Тэр ч утгаараа Монгол Улсын цолжилт, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал дэлхий дахины анхааралд өртөх юм. Энэ бүхнийг овжин мэдэрч, уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн улс орнуудын анхаарлыг тун мэргэн аргаар татаж чадсан салбарын сайдаа талархах нь зүйн хэрэг биз. Мод тариад

орхих биш ургуулсан модоо эргэж хянадаг, цаашлаад уур амьсгалын өөрчлөлт, цолжилт зөвхөн мод тарих төдийнхөөр хэмжээгүй гэдгийг элчин сайдууд онцолж, энэ талаар ч хамтарч ажиллах хүсэлтээ илэрхийлсэн нь нэгэн том дэвшил болж чадсан юм. Уул уурхайн нөхөн сэргээлт, цолжилтийн эсрэг тууштай тэмцэж буй төрийн бус байгууллагуудыг дэмжих, салбар яамны ажилд дэмжлэг болохоо амласан элчингүүдийн амлалт ажил хэрэг болж гэмээнэ олон жилийн мөрөөдөл маань сая л биеллээ олох учиртай. Монголын асуудалд зөвхөн монголчуудад хамаагүй гэдгийг харуулж, цолжилтийн эсрэг динломат харилцаатай улс орнуудаа нэгтгэж чадсан Д.Оюунхорол сайд ч овоо сүйхээтэй юм аа.

МЭДЭЭЛЭЛ

### “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл”-ийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэв

“Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл” сэдэвт үндэсний хэлэлцүүлэг өнгөрсөн баасан гарагт боллоо. Энэхүү хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, НББСПУ-ны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан болон яамны газар болон холбогдох албаны хүмүүс оролцлоо. Мөн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын Хөдөлмөрийн байгууллага, Японы олон улсын хамтын ажиллагааны “ЖАЙКА” байгууллагын төлөөлөгч, төслийн ажилтан зэрэг нийт 160 гаруй хүмүүс оролцсон юм. Хэлэлцүүлгийг нээж, ХНХ-ын сайд Н.Номтойбаяр “Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан багц хуулийг 1995 оноос мөрдөж эхэлснээс хойш багц хуульд 20 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь нийгэмд үүсээд буй зарим асуудлыг тодорхой хугацаанд шийдвэрлэсэн боловч өнөөгийн нөхцөлд шинээр үүссэн, цаашид үүсэх асуудлыг нэг мөр шийдвэрлэж чадахгүйд хүрээд байна. Мөн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс хүн амын хөгжил, тэтгэврийн шинэчлэл, малчдын талаар баримтлах бодлогууд болон Монгол Улсын Засгийн

газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн найруулах ажлыг эхлүүлээд байна” гэв. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар байгуулсан ажлын хэсгээс боловсруулсан “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл”-ийн анхны хувилбар, Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, нийгмийн даатгалын бусад хуулиудад оруулах зохицуулалт, хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн төслийн талаар танилцуулав. Энэ үеэр хэлэлцүүлэгт оролцогчид ч өөрсдийн байр суурийг илэрхийлсэн юм.

### Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийг “нээлтэй хаалганы өдөрлөг”-т урьж байна



өдөрлөгийг зохион байгуулах юм. Өдөрлөгийн үеэр худалдан авах ажиллагаанд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, цахим тендер шалгаруулалтын шинэ системийн талаар мэргэжлийн баг зөвлөгөө өгч, цахим тендерт оролцогчийн нууцлалын код олгох юм. Мөн улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжиж буй тендерийн талаар бүх төрлийн мэдээлэлээр хангах, тендерт оролцогчид хууль журм, жишиг бичиг баримтын талаар зөвлөгөө өгнө. Иргэдийн хувьд Олон нийтийн оролцоотой худалдан авалтын талаар мэдээлэл авахаас адна оршин суугаа дүүрэг хороондоо хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

Тендерт оролцогч аж ахуйн нэгж, иргэд болон төрийн үйлчилгээг нэг цэгээс хүртэх сонирхолтой олон нийтийг өнөөдөр 10-17 цагийн хооронд Сүхбаатарын талбайд болох “Нээлтэй хаалганы өдөрлөг”-т урьж байна.

Энэ өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх ба иргэд, аж ахуйн нэгжийн санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор

АЙЛЧЛАЛ



Үргэлжлэл. Түүрүү нь I нүүрт

Үүнээс гадна тус улсын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчянтай албан ёсны хэлэлцээ хийв. Тодруулбал, хэлэлцээний хүрээнд талууд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх болон байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах асуудлаар голчлон санал солилцлоо. Мөн Тавантолгойн ордод түшиглэсэн газрыг түшиглэн цахилгаан станц барих төслийг даруй эхлүүлэх, “Хэрлэн говь” төслийг Хятадын талтай хамтран хэрэгжүүлэх, Замын-Үүд-Эрээн боомтын хамтын ажиллагааг өргөжүүлэх дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг хамтын ажиллагааны асуудлаар ярилц-

лаа. Хэлэлцээний дараа Ерөнхий сайдыг дагалдан явсан бизнесийн төлөөлөл болон яам агентлагийн албан тушаалтнууд 21 санамж бичигт гарын үсэг зурж, томхон төсөл хөтөлбөрүүдийг гараанаас гаргахаар болов. Тухайлбал, “Хөгжлийн зам” болон “Бүс ба Зам” санаачилгыг уялдуулах тухай манай улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгээс гадна сургууль цэцэрлэг барих хоёр улсын солилцоо захидал, тус улсын санхүүжүүлэх 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр шинээр барих төслийн тусгайлан хэлэлцээр зэрэг 21 томоохон хэлэлцээг албан ёсоор гарын үсэг зурж баталгаажуулав. Ерөнхий сайд айлчлалынхаа хүрээнд зөвхөн тус улсын төрийн тэргүүнтэй уулзаад өнгөрсөнгүй. “Бүс ба зам” олон улсын хамтын ажиллагааны уулзалтад оролцсон ОХУ-ын төрийн тэргүүн В.Путинд бараалхаж хоёр улсын хамтын ажиллагааны талаар ярилцсан бол Польш, Унгарын Ерөнхий сайдтай ч хамтын ажиллагааны олон асуудлаар яриа хэлцэл хийснээр энэ удаагийн айлчлалаа ганзага дүүрэн өндөрлөв.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**  
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**  
90873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**  
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**  
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**  
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**  
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**  
99998796

Маркетинг, зар сурталчлаланы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**  
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**  
99042510

**Э.САЙНЗАЯА**  
99197866



Дугаарыг эрхлэсэн **Б.ӨНӨРТОГТОХ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ



Дугаарын 60 мөр

## Арчлахгүй байж мод тарьж яана аа

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Ялангуяа төрийн өндөр албан тушаалтан, эрх мэдэлтнүүд энэ төрлийн үйл ажиллагаанд оролцож, нэг мод суулгаснаа мод тариад ургуулчихсан хүн шиг санаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, шоу хийх юм. Ингээд хэлэхээр “Ард иргэдийг мод тарих үйлсэд уриалахын тулд” хэмээн өөрсдийгөө зөвтгөж, алдаагаа хаацайлах биз. Гэхдээ та нар ажлаа хангалттай сайн хийлээ. Ард иргэд бүгд л мод тарихыг хичээж, суулгадаг болсон. Одоо харин шоугаа багасгаад суулгасан модоо өөрсдөө чадахгүй юм гэхэд мэргэжлийн хүнд нь мөнгийн нь өгөөд ургуулахын төлөө ажилламаар байгаа юм. “Мод тарих нь нэг өдөр тарьж, мянган өдөр арчилахын нэр юм” гэдэг үг байдаг шүү дээ. Өнгөрсөн долоо хоногт Монгол Улс даяар үндэсний мод тарих өдөр тохиолоо. Энэхүү өдрөө үр дүнтэй тэмдэглэн өнгөрүүлсэн нь ч хүн бүхний нүдэнд ил. Цахим ертөнцөд чих тавихад мод тариагүй хүн үгүй юм байх аа. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2000 мод тариала. Баянзүрхчүүд 1379 мод тарьсан л сурагтай. Олимпын баг тамирчдын эхлүүлсэн төсөлд 1000 мод тарьсан л гэнэ. Дээрх гуравхан жишээнээс харахад, манай улсын мод 4379-өөр нэмэгдлээ. Мөн элчин сайдуудыг мод тарихад уриалж, цөлжилтийн эсрэг тэднийг нэгтгэж чадсан нь хамгийн чихэнд чимэгтэй мэдээлэл байв. Энэ мэтчилэн мод тарих аян 21 аймаг, есөн дүүрэгт үргэлжилж буй. Бид найман жилд 10 сая 100 мянган мод тарьсан гэвэл ирэх найман жилд энэ тоо 20 сая 200 мянга болж нэмэгдэх нь. Гэхдээ суулгасан мод болгоноо өдөр бүр арчилж, ургуулаад байвал шүү дээ. Өдөр бүр биш юм гэхэд нэг хүн суулгасан модоноо долоо хоногт эрх бүлэгтэй ирээд байвал жинхэнэ “мод тарих” өдрийн утга гарах учиртай. Үгүй юм аа гэхэд тарьсан модоо хэсэг хэсгээр нь мод арчилгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад харнуулаж байвал дээрсэн. Манай улс 2012 оноос хойш жилд 2-5 тэрбум төгрөгийг ногоон байгууламжийн ажилд төсөвлөж эхэлжээ. Харин дээрх санхүүжилтийн тал хувийг нь мод тарих ажилд зарцуулдаг гэх. Таван тэрбумын тал нь 2.5 тэрбум төгрөг болно. Тэгвэл сайд, дарга нар, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд зөвхөн “мод тарьсан” гэх нэрийдлээр хэвлэл мэдээллийн хараанд өртөхийн тулд жил бүр дээрх хэмжээний мөнгөөр шоу хийж байна гэсэн үг. Найман жилд 20 гаруй тэрбум төгрөгөөр шоу хийнэ гэдэг арай л дэндүү юм. Мод суулгачихаад л “Би мод тарьчихлаа” хэмээн зургаа авахуулахыг Монгол Улсын найман настай балчирас наян настай буурал ч хангалттай хийж чадахаар болчихлоо. Тиймээс улс орон, хойч ирээдүйтэй холбоотой асуудлаар шоу хийхээ болиод суулгасан ганц бутгаа арчилж, ургуулаад мод болгох талаар анхаарах гэж хүсье. Арчилж чадахгүй бол чаддаг нэгнийх нь ажилд 10 мянган төгрөг хандивлачихвал тэр ч бас буян шүү дээ.

# МАН, АН НЭР ДЭВШИГЧИД ШАЛГУУРТ ТЭНЦЭЖ, МАХН БУДРЭВ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хэдийгээр нам дундаасаа нэг хүнийг сонгон нэр дэвшүүлж, СЕХ-нд бичиг баримтаа хүлээлгэж өгсөн ч хуульд заасан шалгуурыг хангаагүй бол буцаах эрх нь Сонгуулийн Ерөнхий хороонд бий. Тэр тохиолдолд улс төрийн намууд дахин хуралдаж шалгуурт нийцсэн улстөрчийг хуульд заасан эцсийн хугацаа буюу энэ сарын 17-ны дотор амжиж тодруулах учиртай юм. Харин хоёр том намын өрсөлдөгчид хуулийн шаардлагыг хангасан учраас ийнхүү “тулаанд” албан ёсоор оролцох эрхээ авч чадлаа.

дурдсанаар түүнийг ялтайд тооцох хугацаа энэ оны наймдугаар сарын 2-нд дуусна/ Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь 5-аас доошгүй жил эх орондоо тасралтгүй оршин суусан байх шаардлага хангаагүй гэж үзжээ. Тодруулбал, Н.Энхбаяр нь 2013 оны наймдугаар сарын 13-наас 2014 оны аравдугаар сарын 9-ныг хүртэл буюу 13 сарын турш эх орондоо байгаагүй гэж үзэж бүртгэхээс татгалзжээ. Харин жагсаал цуглаан хийгээд байсан намын гишүүд нь намын даргад нь татгалзсан санал өгсөнтэй холбогдуулж олоогүй болон зарлах тухай асуудлаар өчигдөр намынхаа байранд хуралдсан аж.

байранд хүч түрэн дайрч орж, үймээн үүсгэлээ. Чингэлтэй дүүргийн цагдаагийн албан хаагчид хэдхэн ахмадуудаас болж, амралтын бүтэн өдрөөрөө өндөржүүлсэн бэлэн байдалд ажилласан гэхэд хэгийдэхгүй. Уг нь МАХН-ынхан хуулиа мөддэг, хүндэлдэг байсан бол төрийн албан хаагчдыг үл тоож, төрийн байгууллагын ажилд хөндлөнгөөс оролцож гэж улайрахгүй байлаа. Тэд бичиг баримтаа хүйлээлэн өгснийхөө маргаашнаас эхлэн СЕХ-ны үүдэнд жагсч пуглаж, намын даргыгаа бүртгэхийг шаардаж эхэлсэн юм. Хуулийн дагуу шийдвэр гаргахыг хүлээхгүйгээр жагсч тэмцэж эхэлсэн нь ч асуудалтай. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын ажилд хөндлөнгөөс оролцож, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх оролдого хийсэн гэхэд буруудахгүй. Н.Энхбаярын хувьд өмнө нь ял эдэлж байсан нь худлаа биш. Хэдийгээр өршөөлд хамрагдсан ч ялтай байх хугацаа нь дуусаагүй гэдгийг хууль хяналтын байгууллага удаа дараа мэдэгдсэн. Монгол Улсын Үндсэн хуульд ял эдэлж байсан хүн Төрийн тэргүүний болон бүх шатны сонгуульд өрсөлдөж болохгүй хэмээн тод томруунаар заагаад өгчихсон учраас тэд хуулиа л дагаж мөрдсөн хэрэг. Гэтэл ахмадууд

голдую оролцсон МАХН-ыг жагсагчид цагдаа нарыг зүй бусаар доромжилж, намын даргыгаа бүртгэсэн эсэх шийдвэрийг шууд гаргаж өг хэмээн давшлав. Мөн намын даргатайгаа хамт СЕХ-ны албан ёсны хурал руу орно хэмээн үймээн дэгдэж, хүчний байгууллагын эсэргүүцэлтэй тулгарлаа. СЕХ-ны хуралд намын дарга Н.Энхбаяр оролцож, өөрийгөө өмгөөлөн тайлбар хийсэн юм. Гэхдээ шийдвэр гаргагч нь СЕХ биш учраас Үндсэн хуулиа дагаж ялтай хүнийг нэр дэвшүүлсэнгүй. Ингэснээр Ерөнхийлөгчийн суудлын төлөөх өрсөлдөөн МАН, АН нэр дэвшигчдийн дунд өрнөх нь тодорхой болж байна. Ерөнхийлөгчийн суудлын төлөөх өрсөлдөөн ийнхүү албан ёсоор эхэллээ.

### МАХН өөр хүнийг нэр дэвшүүлэх үү, эсвэл...

Нэр дэвшигчид хуулийн шалгуур хангасан, хангаагүйг албан ёсоор баталгаажуулсан тогтоол гарсны дараа МАХН-ынхан хэчнээн эсэргүүцэл тэмцэл өрнүүлээд ч нэмэр болохгүй. Н.Энхбаяр шалгуур хангаагүй л бол өлсгөлөн зарлаж, шүүгэл үлээгээд ч төрийн хуулийг өөрчлөх боломжгүй билээ. Үүнийг МАХН-ын туршлагатай, ахмад улстөрчид мэдэж буй. Үнэхээр л тэд шударга ёсыг мөрддөг, хуулиа дээдэлдэг бол төрийн байгууллагын шийдвэрийг дагаж мөрдөх нь ард түмнээ хүндэлж буй нэг хэлбэр болох билээ. МАХН-ынханд энэ сарын 17-ноос өмнө шалгуурт нийцсэн өөр нэгнийг нэр дэвшүүлэх боломж бий. Эс бөгөөс хоёр том намын аль нэг нэр дэвшигчийг дэмжиж сонгуульд оролцох боломж ч бас байгаа. Тэд ямар шийдвэр гаргах нь өнөөдөр тодорхой болно. Улмаар эцсийн хугацаа буюу 17-ныг хүртэл тэд ямар улс төр хийхийг хүлээх л үлдлээ.

### Н.Энхбаяр шалгуурт бүдэрчээ

Харин МАХН-ын дарга Н.Энхбаярт татгалзсан харну өгчээ. Татгалзсан шалтгаанаа тэд хилийн албаны тодорхойлолт хавсаргаагүй. Ял шийтгүүлж байгаагүй гэсэн шаардлагыг хангаагүй. Өөрөөр хэлбэл, ялтайд тооцох хугацаа дуусаагүй. /ЦЕГ-ын тодорхойлолт болон Сүхбаатар дүүргийн шүүгчийн

### МАХН-ынхан үймээн тариллаа

Амралтын өдрөөр хуралдсан ч СЕХ-ны нэр дэвшигчийг баталгаажуулах хуралдаан тун ч дуулиан шуугиантай болов. Ажлын бүс амралтын өдрийг тааруулж хуралдсан нь төрийн хуулийг үл тоож, хор найруулах гэсэн башир АХН-ынхан илэрхийлсэн. Улмаар намын даргаа ялтай байхаас үл хамаарч Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх чин хүслээр СЕХ-ны

### ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# ЗАЛУУЧУУД БИЕ ДААСАН ХУУЛЬТАЙ БОЛОХ НЬ

Б.ӨНӨР

Өнгөрөгч долоо хоногийн УИХ-ын чуулган дандаа хууль, шүүхийн байгууллагатай холбоотой хууль тогтоомжийг хэлэлцэв. Олон жилийн турш маргаан дагуулсан, нөгөөтэйгүүр хүний эрхийн асуудлыг тусгасан эдгээр хуулиудыг залуу гишүүдэд даатгаж орхисон нь шүүмжлэл дагуулж байсан юм. УИХ-ын гишүүн болоод нэг жил ч болоогүй залуу гишүүдээр хүний эрхтэй холбоотой, тооцоо судалгаа хийгдэх том хуулийн төслүүдийг ахлуулж, тэд нь асуудлаа ойлгохгүй хуулийн зүйл заалтыг буруу тайлбарлах, мушгин гуйвуулах асуудал их байгааг МАН, АН-ын гишүүд шүүмжилж байлаа. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Пүрэвдорж Эрүү болон Зөрчлийн хууль “завхарсан” учраас луухгарууд хойш сууж, залуучуудаар балнар зүйлээ хийлгэж байна хэмээлээ. Мөн хэлэлцэж дуусаагүй байхад эргэж шинэчлэх ёстой, зүйл заалтаа засах тухай санал ч гишүүдийн зүгээс гарч байсан юм. Энэ долоо хоногт Зөрчлийн хуулиас гадна Нялх балчир хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний тухай хуулийг эцэслэн баталсан нь олон нийтийн дунд маргаан үүсгэсэн юм. 0-6 сартай хүүхдийг зөвхөн эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн энэхүү хууль нэмэлт бүтээгдэхүүн өгсөн эхийг торгох зүйл заалтыг



агуулсан аж. Хүүхдээ эхийн сүүгээр хооллох нь зөв ч хатуу хуульчилж өгснөөр хөхний сүү орлуулагч бүтээгдэхүүнийг нууцаар зарах, улмаар хяналтгүй болох сөрөг талтай. Нөгөө талаар хийсвэр хагалгаанд орсон ээжүүд нэмэлтээр эхний гурав хоногт хүүхдээ угжихаас өөр аргагүйд хүрдэг. Гэтэл хатуу хуульчилж өгснөөр хүүхдээ харангадуулах сонголт өгч байна хэмээн бухимдаж байлаа. Харин салбарын сайд эмчийн зааврын дагуу өгөх болон төрөх эмнэлгүүдэд эхийн сүүний банк байгуулах учраас ийм асуудал гарахгүй хэмээн мэдэгджээ.

Баасан гарагийн чуулганаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчил шалган шийдвэрлэх гэсэн хоёр хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлэв. Мөн энэ өдөр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас өргөн мэдүүлсэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Төслийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хорооны санал

дүгнэлтийг УИХ-ын гишүүн, байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан танилцуулсан юм. Ингээд хуулийн төсөлтэй холбоотой байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалаа. Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачилж өргөн мэдүүлсэн Залуучуудын хөгжлийн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр НББСПУ-ны байнгын хороонд шилжүүллээ. Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу салбарын яамнаас уг хуулийн

төслийг боловсруулснаар 15-34 насны залуус анх удаа бие даасан хуультай болох боломж бүрдэж байна. Одоогоор залуучуудад чиглэсэн ямар нэгэн бодлого, хөтөлбөр байхгүй байна. Тиймээс нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үзүүлж тодорхойлох, төрөөс залуучуудад үзүүлэх дэмжлэг, залуучуудын хөгжлийг дэмжих төрийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай болоод байсныг ХНХЯ-наас ийнхүү шийдвэрлэхээр зорьж байгаа юм. Хуралдаанаар

үргэлжлүүлэн А.Ундраа, Б.Батзориг нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хэлэлцэх эсэхийг хэлэлцлээ. Хуулийн төсөл санаачлагчийн илтгэлийг А.Ундраа гишүүн танилцуулсан бөгөөд хүн амын дунд явуулсан амин дэм, эрдэс бодисын дутлын талаарх судалгааны дунд баяжуулсан хүнсний талаар бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх зайшгүй шаардлага тулгарсныг харуулж байна хэмээн танилцуулгадаа онцоллоо. Тухайлбал, Хүн амын эрдэс, амин дэмийн дутлын судалгааг түүвэрлэн авч үзвэл 7.4 хувь нь иодын, 28.5 хувь нь гемоглобины, 21.4 хувь нь төмрийн, 32.4 хувь нь А, 42.4 хувь нь Д амин дэмийн дуталтай болохыг тогтоожээ. Эрүүл мэндийн яамнаас 2016 онд явуулсан хүн амын хоол тэжээлийн үндэсний тавдугаар судалгаагаар 0-5 насны хүүхдийн 4.7 хувь өсөлтийн ходролдтой, 15-64 насны хүн амын 54.4 хувь нь жингийн илүүдэлтэй, 26-64 насны хүн амын 61.7 хувь нь цусан дахь холестерин хэмжээ ихсэх эрсдэлтэй, нас баралтын 80 хувь нь зохисгүй хооллолтоос үүдэлтэй байсан байна. Хуулийн төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байгаагүй учраас анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлэв.

## ЦАГ ҮЕ

ТОМИЛОЛТ

# Сэлэнгийнхэн төрөөс шийдвэр “НЭХЭЖ БАЙНА”



Гэрэл зурагч Г. АРТУУЖИЛ

## Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тус хурлыг нээж Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа үг хэллээ. Тэрбээр “Сэлэнгэ аймагт Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутагт баримтлах бодлого чиглэл, Эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх чиглэл, Бэлчээр ашиглалтыг сайжруулах тухай тогтоолуудыг гарган, гадны аймаг сумдаас мал оруулахыг хориглож, малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицолыг хангах журмыг хэрэгжүүлж байгаа. Гэсэн хэдий ч, газар тариалан мал аж ахуйн зохистой харьцаа алдагдан малчид тариаланчдын хоорондын үл ойлголцол, үйл ажиллагааны зөрчил байсаар байна. Зарим сумдад тариаланч, малчдын үйл ажиллагааны зөрчил улам бүр ихэсч, ахуй амьдрал болон оршин тогтнохуйн хурц тэмцэл болж, иргэний хэргээс эрүүгийн хэрэг хүртлээ даамжрах хандлага ажиглагдах боллоо. Монгол Улсад хадлан тариа хэрэгтэй юм бол, монгол хүнд гурил, талх тариа хэрэгтэй юм бол Сэлэнгэ аймгийн эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхлэх стратегийн бүс нутаг болгон зарлаж, хослуулан хөгжүүлэх талар төр засаг шийдвэр гарган хэрэгжүүлэх цаг хугацаа нь болсон гэж үзэж байна. Зөвхөн малчид, тариаланчдын хоорондын зөрчил гэхээсээ илүүтэй газар тариалангийн салбарын шинэ техник, технологийг хөгжүүлэх, цаашлаад байгаль экологид сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах өргөн утгатай хойшлуулшгүй шийдвэрлэвэл зохих амьдрал үйл ажиллагааны чухал асуудал болоод байна” хэмээн онцоллоо.

Мөн нэн яаралтай асуудлыг шийдвэрлэхгүй бол цөлжилт улам бүрхэсч, бэлчээрийн менежмент бүрэн алдагдаж, үржил шимт хөрс, бэлчээргүй болох аюул хаалга тогшиж буйг хуралд оролцогчид ойлгож, үнэтэй санал зөвлөмж өгнө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж байв.

## Сэлэнгэ аймагт 192 эрчимжсэн мал аж ахуй үйл ажиллагаа явуулдаг

Ийнхүү үндсэн илтгэлүүд эхэлж, ХХААХУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга Эрчимжсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн талаарх бодлого чиглэлийн талаар танилцуулсан бол Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил “Сэлэнгэ аймгийг Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгох шаардлага боломж, зорилт” сэдвээр илтгэл тавилаа.

Сэлэнгэ аймаг нь жил бүр улсын хэрэгцээт үр тарианы 60 орчим

хувь, төмсний 28 хувь, хүнсний ногооны 36 хувийг дангаар бэлтгэж, газар тариалангийн үйлдвэрлэлээр улсад тэргүүлэх байр сууриа хадгалсаар ирсэн. Аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд жилд дундажаар нийт 176619 га талбайд тариалалт хийж, 147370 га-д үр тариа, 5438 га-д тэжээлийн ургамал, 23791 га-д төсны ургамал, 3276 га-д төмс, 2545 га-д хүнсний ногоо тус тус тариалж, 237865 тн улаанбуудай, 6173 тн бусад үр тариа, 11034 тн тэжээлийн ургамал, 10119 тн төсны ургамал,

хангалтад сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн нь анхаарал хандуулах гол сэдэв болж байна. Тиймээс Сэлэнгэ аймгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхлэх бүс нутаг болгон тогтоож, малын тоог бууруулж, малаа тодорхой бүс нутгуудад байршуулах асуудлыг УИХ, Засгийн газар, ХХААХУ-ийн яам болон холбогдох байгууллагууд анхааралдаа авч нэн яаралтай шийдвэрлэхэд хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна” хэмээн онцлон дурьдлаа.



41888 тн төмс, 31846 тн хүнсний ногоо тус тус хураан авсан байна. Гэвч, аймгийн газар тариалангийн хөрсний үржил шим буурах, элэгдэл эвдрэл, цөлжилтөнд өргөх, малын тоо толгой, бэлчээрийн даацын харьцаа алдагдсанаас ургацад үзүүлэх сөрөг нөлөө ихсэж байгаа нь анхаарал татаж байгааг аймгийн Засаг дарга Ш.Оргил илтгэлийнхээ үеэр онцолж байсан юм.

Тэгвэл өнөөдрийн байдлаар Сэлэнгэ аймагт 192 эрчимжсэн мал аж ахуй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүний голлох чиглэл нь мах-сүүний үхэр, мах-ноосны чиглэлийн хонины аж ахуй байгаа аж. Малын тоо толгойн өсөлт нь гадны аймаг сумаас ирж буй механик өсөлтөөс шууд хамаарч, бэлчээрийн даац 2.8 дахин хэтэрсэн байна. Энэ талаар Ш.Оргил илтгэлдээ “Бэлчээрийн даацаас хэт их болсон мал, зөвхөн тариалан талбайд орж хохирол учруулахаас илүүтэйгээр уриншилсан талбайд орж хөрс нягтруулж, хөрсний бүтцийг алдагдуулан авах ургацын хэмжээг бууруулж, стратегийн бүтээгдэхүүн болох буудайн

## Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүсэд Сэлэнгэ багтаж байна

Сэлэнгэ аймгийн тухайд эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлэх хэд хэдэн давуу талтай. Тухайлбал, газар тариалангийн чиглэлээр байгаль, цаг агаар, уур амьсгал, хөрсөнд хуримтлагдах жилийн дулаан, хөрсний бүтэц тохиромжтой байдал, тариалангийн хөгжил, бэхжсэн бааз, уламжлагдаж, туршлагажсан арга, эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байсан туршлага, энэ чиглэлийн мэргэжлийн ажиллах хүчин нөөц, тэжээл үйлдвэрлэл, хадлан бэлтгэлт, ашиг шимт мал сүргийн дийлэнх нь байдаг гээд давуу тал олонтой. Тэгвэл олон улсын бага хурлын үеэр “Бүсчилсэн хөгжлийн бодлого ба Сэлэнгэ аймгийн орон зайн төлөвлөлтийн онцлог” сэдэвт илтгэлдээ Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын талтсийн

ахлах мэргэжилтэн С.Намжилмаа хөндлөнгийн байгууллагын хийсэн судалгааны дүнгээр Сэлэнгэ аймаг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүсэд багтаж буйг тодотгож байлаа. Түүний дурьдсанаар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ын боловсруулсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”-ны тайланд тусгагдсан “Хөндлөн тэнхлэгийн ногоон коридор” буюу хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүсэд Сэлэнгэ аймаг орж байгаа төдийгүй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад тохиромжтой нөхцөлтэй гэж үнэлсэн байна. Энэ мэтээр Сэлэнгэ аймгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг зүй зохистой хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгох хэрэгцээ, шаардлага, боломж, арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр олон талаас нь өргөн хүрээнд хамтран хэлэлцлээ. Мөн хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгуулахаар санал хүсэлтээ нэгтгэж эрх бүхий байгууллагад уламжлахаар болсон юм. Хурлын үеэр малчид тариаланчид Монгол Улс дан уул уурхайгаар хөгжингүй, газар тариалан, мал аж ахуйн салбарыг хослуулснаар хөгжинө. Тиймээс газар тариалан, мал аж ахуйн салбарыг онцгойлон анхаарч эрчимжүүлж хослуулан хөгжүүлэх хэрэгтэй байгааг онцолж байлаа.

## Сэлэнгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн стратегийн бүс болгохыг иргэдийн 76.5 хувь нь дэмжжээ

Бага хурлын төгсгөлд Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр “Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болох нь” сэдэвт сумдын хэлэлцүүлгийн болон малчдаас авсан судалгааны дүнгийн тухай танилцуулсан юм. Тодруулбал, тус аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас өнгөрөгч гурав, дөрөвдүгээр сард малчид тариаланчид, мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулжээ. Уулзалтад 16 сумын 1700 гаруй малчин, тариаланчид, багийн Засаг дарга, мэргэжилтнүүд оролцсон бөгөөд тэдний 76.5 хувь нь Сэлэнгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болгох саналыг дэмжсэн байна. Улмаар зөвлөлдөх уулзалтад оролцогчид нийтдээ 324 санал гаргасныг 21 багц болгож, онол, үйлдвэрлэлийн бага хурлын үеэр танилцуулсан юм. Тухайлбал, тэрхүү багц

саналуудад газар тариалангийн бүс нутагт байх малын тоо толгойг тогтоох, тогтмол хэмжээнд барих, Мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилэн хөгжүүлж, эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлэхэд төрийн бодлогоор дэмжих, Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй малчдаас бэлчээршигласныг татвартогтоох, өөр аймгаас отор нүүдлээр ирсэн тавиул малыг мал эмнэлгийн үзлэг оношлогоонд оруулж, тоог хонин толгойд шилжүүлж, нэг хониноос 50 мянган төгрөгийн хураамж авах, Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн уялдаа холбоог нарийвчлан тогтоож, малчдад шаардлага бүхий ургамлыг тариаланчдад захиалгаар тариалах боломжийг бүрдүүлэх, бүс нутагт Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх жишиг загварыг тодорхойлох зэрэг багц саналууд гарсан байна. Энэ үеэр зарим зочид төлөөлөгчидтэй уулзаж, санал бодлыг нь сонсолоо хүргэе.

## Л.Чинбат: Газар тариалангүйгээр мал аж ахуй эрчимжих боломжгүй

“Гацуурт” ХХК-ийн захирал,  
МУ-ын Хөдөлмөрийн баатар/

-Манайх 2001 оноос Сэлэнгэ аймгийн 10 гаруй суманд 300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Тэгэхдээ эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн төслөө хамтад нь эхлүүлсэн. Гэвч, тухайн үед зарим сум орон нутаг ойлгоогүй. Тийм учраас манайх ихэвчлэн Цагааннуур, Түшиг сумдад түшиглэн үйл ажиллагаагаа явуулсан. Харин одоо цаг үе өөрчлөгдөж, зарим сумдаас хүсэлт ирж байна. Өнгөрсөн хугацаанд цэвэр махны чиглэлийн 2000 гаруй ангус үүлдрийн үхэр өсгөн үржүүлж, Монгол Улсын аймаг бүрт хүрчихлээ. Одоо бид лаборатори байгуулж байгаа. Лаборатори нээгдсэнээр зохиомол хээлтүүд хийх боломжтой болох юм. Цаашдаа төр засгаас бодлогын төвшинд дэмжвэл бид үр хөврөлийг нийт монголчууддаа үнэ төлбөргүй нийлүүлэх боломжтой. Энэ бол зөвхөн эхлэл нь. Монгол Улс эхлээд малаа бүртгэх ёстой. Бүртгэсэн малаа эрүүлжүүлж, хээлтүүлгийнх нь асуудлыг шийдсэнээр чанар чансаа нь сайжирна. Харин дараа нь тэжээлийнхээ асуудлыг шийдэх ёстой. Бүхий л үйл ажиллагаа хоорондоо уялдаа холбоотой байх хэрэгтэй. Эцэст нь, малчид малаа үйлдвэр нь гадаадад экспортлох, дотоодын хэрэгцээнд нийлүүлэх зэргээр шат дараатай байх ёстой. Газар тариалангийн салбар эрчимжиж, тодорхой үр дүнд хүрчихлээ. Одоо мал аж ахуйгаа

эрчимжүүлэх шаардлагатай байна. Газар тариалангүйгээр мал аж ахуй эрчимжих боломжгүй. Харин хоёуланг нь хослуулан хөгжүүлснээр иргэдийн орлого нэмэгдэж, орон нутагтаа сайн сайхан амьдрах боломж нээгдэнэ. Үүнийг л малчид, тариаланчид маань ойлгож, хамтарч ажиллах шаардлагатай байна. Өмнө нь улсаас эрчимжсэн мал аж ахуйн бүсийг ялгаж өгдөг байсан. Харин одоо улсын хэмжээнд нэг аймгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс болгохоор зорьж ажиллаж буйг нь миний хувьд дэмжиж байна.

## Ц.Пүрэвхүү: Сэлэнгэ аймагт 1977 оноос хойш худалдааны хориг тавигддаг малын өвчин гараагүй

/Мал эмнэлгийн үржлийн  
газрын мэргэжилтэн/

-Дэлхийн чиг хандлагыг харахад эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нэг хэсэг байна. Цөөн тооны чанартай малтай, дээр нь тодорхой бэлчээр нутагтай учраас тэр бүр хол нүүдлэхгүй. Энэ тохиолдолд мал эмнэлгийг үйлчилгээг хүргэхэд илүү дөхөм байдаг гэсэн үг. Одоогийн нөхцөлд 200-300 км-ын цаан нүүдэллэсэн 1000 малтай өрхөд мал эмнэлгийн үйлчилгээг хүргэхэд гаргасан зардал, өртгөө эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн төслөө хамтад нь эхлүүлсэн. Гэвч, тухайн үед зарим сум орон нутаг ойлгоогүй. Тийм учраас манайх ихэвчлэн Цагааннуур, Түшиг сумдад түшиглэн үйл ажиллагаагаа явуулсан. Харин одоо цаг үе өөрчлөгдөж, зарим сумдаас хүсэлт ирж байна. Өнгөрсөн хугацаанд цэвэр махны чиглэлийн 2000 гаруй ангус үүлдрийн үхэр өсгөн үржүүлж, Монгол Улсын аймаг бүрт хүрчихлээ. Одоо бид лаборатори байгуулж байгаа. Лаборатори нээгдсэнээр зохиомол хээлтүүд хийх боломжтой болох юм. Цаашдаа төр засгаас бодлогын төвшинд дэмжвэл бид үр хөврөлийг нийт монголчууддаа үнэ төлбөргүй нийлүүлэх боломжтой. Энэ бол зөвхөн эхлэл нь. Монгол Улс эхлээд малаа бүртгэх ёстой. Бүртгэсэн малаа эрүүлжүүлж, хээлтүүлгийнх нь асуудлыг шийдсэнээр чанар чансаа нь сайжирна. Харин дараа нь тэжээлийнхээ асуудлыг шийдэх ёстой. Бүхий л үйл ажиллагаа хоорондоо уялдаа холбоотой байх хэрэгтэй. Эцэст нь, малчид малаа үйлдвэр нь гадаадад экспортлох, дотоодын хэрэгцээнд нийлүүлэх зэргээр шат дараатай байх ёстой. Газар тариалангийн салбар эрчимжиж, тодорхой үр дүнд хүрчихлээ. Одоо мал аж ахуйгаа



# МЭДЭЭЛЭЛ

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос дүүргийн нутаг дэвсгэр дэх "Очир худалдааны төвөөс "МТ" шатахуун түгээх станц хүртэл авто замын дагуу тарих гацуур мод, тулгуур мод"-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50'000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 10.40 цаг-т нээнэ.

**Дотоодны давуу эрх: "Тооцохгүй"**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба.  
Утас:7023-2788

## ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017-05-15

**Тендер шалгаруулалтын нэр:** Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах инженерийн хийцтэй худаг гаргах,  
**Тендер шалгаруулалтын дугаар:** 2017-A002

[Аймгийн засаг даргын тамгын газар] эрх бүхий тендерт оролцогчдоос [Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах инженерийн хийцтэй худаг гаргах]-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь [50 000] төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**  
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жилийн / 2014, 2015, 2016 / дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 70%-аас багагүй байна]

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50%-аас багагүй байна.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2014, 2015, 2016, оны санхүүгийн тайлан /аудитаар баталгаажсан байна

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын

**өрөгт:** Сүүлийн 3 жилийн / 2014, 2015, 2016 / дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 70%-аас багагүй байна

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
5.3 Цооног өрөмдөх, худаг гаргах, сэргээн засварлах, шинэчлэх, усны барилга байгууламж барих, тоноглох

**Барилга, хот байгуулалтын яамны**

2.1.2 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээгдсэн барилга угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар хүртэл/

Тендерийн хамт [1- багц Зүүн зүгийн сумд-2 000 000 төгрөг, 2-р багц Баруун зүгийн сумд-1 500 000 төгрөг] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг [2017 сарын 06 сарын 15-ны өдрийн 15 цаг 00 минут]-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2017 сарын 06 сарын 15]-ны өдрийн, [15 цаг 30 минут]-т нээнэ.

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

[Сүхбаатар аймаг “Орон нутгийн өмчийн газар” /Баруун-Урт сум 7-р баг нутгийн удирдлагын ордон 3 давхарт 306 тоот өрөө.  
Утас : 70518123, С.Баярмаа 99044893/

## ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр:** Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо орон сууцны 7 дугаар хороолол орчим “Б” хэсэгчилсэн талбайн эхний ээлжийн дулаан хангамжийн ажил  
**Тендер шалгаруулалтын дугаар:** НХААГ-17/0116

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо орон сууцны 7 дугаар хороолол орчим Б хэсэгчилсэн талбайн эхний ээлжийн дулаан хангамжийн ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн сүүлийн 2 жилийн /2015, 2016 он/ дундаж нь:**

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувь буюу түүнээс дээш байх.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм  
**Барилга хот байгуулалтын яамны:**

-2.2.4. Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт болон түүнээс дээш

Тендерийн хамт 3,300,000 /гурван сая гурван зуун мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn) -ээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх: Эрхгүй**  
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцно**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,  
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар  
Утас: 75757810  
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. [Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар] нь [Баруун-Урт сумын доторхи 5,5 км ус хангамж, 2 км ариутгах татуургын шугамын шинэчлэлийн ажлын зураг төсөв боловсруулах]-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь [Баруун-Урт сумын доторхи 5,5 км ус хангамж, 2 км ариутгах татуургын шугамын шинэчлэлийн ажлын зураг төсөв боловсруулах]-болно.

3. **Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:** Тийм  
1.3.2 Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (ГБОНӨХБАУХАТ)Хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгууруудыг хангаж буйг нотлох баримт бичгийг ирүүлнэ.

**Үүнд:**

- Байгууллагын ерөнхий танцшуулга
- Байгууллагын гэрчилгээний хуулбар

- Тусгай зөвшөөрлийн хуулбарыг байна
- Сүүлийн 3 жилд /2014, 2015, 2016/ гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлага
- Сүүлийн 3 жилийн /2014, 2015, 2016/ аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан
- Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний чадавхийн талаарх мэдээлэл /Голлох инженер, техникийн ажилчдын ур чадварын мэдээлэл, туршлага, зэргийн үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, гэрээт ажилтан бол ажлын гэрээг хавсаргах/ ирүүлэх
- 5. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.

6. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг [2017.05.15-2017.05.22]-ний [08:00-17:00] хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар [2017 оны 05 сарын 22-ны өдрийн 17:00 минут –]ний дотор ирүүлнэ үү.

[Сүхбаатар аймаг “Орон нутгийн өмчийн газар” /Баруун-Урт сум 7-р баг нутгийн удирдлагын ордон 3 давхарт 306 тоот өрөө.  
Утас : 70518123, С.Баярмаа 99044893/

## ТЭНДЕРИЙН УРИЛГА

2017 оны 05 сарын 15

**Тендер шалгаруулалтын нэр:** Шалгалт тохируулгын лабораторийн багаж хэрэгсэл нийлүүлэх.  
**Тендер шалгаруулалтын дугаар:** АТУГ-17/020

Автогэврийн үндэсний төв ТӨҮТ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Шалгалт тохируулгын лабораторийн багаж хэрэгсэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөгөөр, Төрийн банкны 340004009911 тоот дансанд тушааж, худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**  
**Борлуулалтын хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас дээш байх

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:** Санал болгож буй

үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил

Тендерийн хамт 1.000.000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 11 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 12 цаг 00 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй**  
**Дотоодны давуу эрх тооцохгүй**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, Зам, тээврийн хөгжлийн яамны өргөтгөл, 1-р давхар, 109 тоот Хөрөнгө оруулалт харууцсан мэргэжилтэн Г.Чинзориг. Утас: 99101763

## ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр:** Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Улаанхуаран дэд станцаас 5 мВт цахилгаан хэрэглээг хангах кабель шугам татах ажил  
**Тендер шалгаруулалтын дугаар:** НХААГ-17/0117

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Улаанхуаран дэд станцаас 5 мВт цахилгаан хэрэглээг хангах кабель шугам татах ажил”-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн сүүлийн 2 жилийн /2015, 2016 он/ дундаж нь:

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувь буюу түүнээс дээш байх.

Сүүлийн 2 жилийн /2015, 2016 он/ аль нэг жилд дор хаяж 1 удаа санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:**

Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.

**Эрчим хүчний яамны:**

- 03.9.3-д заасан Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 0.4-110кВ, түүнтэй дүйцэхүйц эсвэл түүнээс дээш заалт

эсвэл Барилга хот байгуулалтын яамны:  
- 1.3.3-д заасан Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /110 кВ хүртэл/, түүнтэй дүйцэхүйц эсвэл түүнээс дээш заалт

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.

**Эрчим хүчний яамны:**  
- 03.2.1-д заасан Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-10кВ, түүнтэй дүйцэхүйц эсвэл түүнээс дээш заалт

эсвэл Барилга хот байгуулалтын яамны:  
- 2.2.8-д заасан Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистраль/ шугам /35 кВ хүртэл/ угсралт түүнтэй дүйцэхүйц, эсвэл түүнээс дээш заалт

Тендерийн хамт 3,610,000 (гурван сая зургаан зуун арван мянга) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn) -ээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 09 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх: Эрхгүй**  
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцно**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,  
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар  
Утас: 75757810  
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

# ДЭЛХИЙ



## САНААЧИЛГАД 600-800 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР ЗАРЦУУЛНА

Б.ДАВАА

“Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалт өчигдөр БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо эхэллээ. Тус уулзалт хоёр өдрийн турш үргэлжлэх бөгөөд өнөөдөр албан ёсоор хаалгаа хийх гэнэ.

Хуралд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Туркийн Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоган, Филиппиний Ерөнхийлөгч Родриго Дутерте нарын 29 улс орны төр, Засгийн газрын тэргүүн, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш, ОУВС-гийн захирал Кристин Лагард, Дэлхийн банкны Ерөнхийлөгч Жим Ён Ким нарын 70 гаруй олон улсын байгууллагын томоохон албан тушаалтнууд оролцож байгаа аж. Үүнээс гадна 130 орны 1500 гаруй төлөөлөгч оролцож байна.

“Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалтыг БНХАУ-ын дарга Си Зиньпин нээж үг хэлжээ. Тэрбээр “Эртний торгоны замын маршрутыг энхийн цагт гаргаж

байсан. Гэвч, дайн дажин үгүй болгосон байдаг. Тиймээс бид “Нэг бүс нэг зам” санаачилгын хүрээнд энх тайван хийгээд тогтвортой хөгжлийн замыг тавих хэрэгтэй. Харилцан ашигтай хамтран ажиллах замаар олон улсын харилцааг шинэ төвшинд гаргаж, үл сөргөлдөх зарчмыг баримтлан түншүүдтэйгээ яриа хэлэлцээр хийх хэрэгтэй. Улс орнууд харилцан бие биенийнхээ тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хөгжлийн зам болон нийгмийн тогтолцоог хүндэтгэх хэрэгтэй. Эртний торгоны замын дагуух зарим бүс сүү, зөгийн балны нутаг байлаа. Харин өнөөдөр эдгээр газар дайн байлдаан, хямралд нэрвэгдээд байна. Бид ийм байдлыг зүгээр хараад сууж болохгүй” гэдгийг онцлон тэмдэглээд, бүх улс орныг хамарсан аюулгүй байдлын орчин нөхцлийг бий болгох шаардлагатайг дэлхий дахинаа уриалжээ. Мөн үргэлжлүүлэн “Бид хөгжлийн үндсэн асуудалд анхаарлаа хандуулж, бүх улс орныг хамарсан эдийн засгийн хөгжлийн замыг тавих хэрэгтэй. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шинэ

загваруудыг бий болгож, засгийн газар, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг илүүтэй дэмжиж, төрөлжсөн санхүүгийн тогтолцоо болоод олон шатлалт хөрөнгийн зах зээлийг бий болгох хэрэгтэй” гэлээ.

Харин дэд бүтцээр холбогдох тухайд тэрбээр “Газар, далай тэнгис, агаар, кибер орон зайгаар холбогдох боломжийг эрэлхийлж, хурдны зам, төмөр зам болон далайн боомтуудын төслүүдэд анхаарлаа хандуулах”-ыг холбогдох бүх улс оронд уриалжээ. БНХАУ-ын дарга Си Зиньпин “Нэг бүс, нэг зам” санаачилгыг анх 2013 онд гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Тэгвэл түүнээс хойшхи анхны томоохон хэмжээний уулзалт нь энэ удаа болж буй гэдгээрээ онцлог юм.

Уулзалтад оролцож буй зочид төлөөлөгчид энэ өдрүүдэд “хамтран ажиллах”, “хамтдаа ашиг хүртэх” гэсэн хоёр чиглэлийн хүрээнд бодлого чиглэл, зам харилцаа, худалдаа, валют солилцоо, ард иргэдийн харилцан ойлголцолыг эрчимжүүлэх зэрэг асуудлыг авч хэлэлцэх ажээ. БНХАУ-ын хөрөнгө оруулагчид 2013 оноос

хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд нийтдээ 60 тэрбум ам.долларыг “Нэг бүс, нэг зам” санаачилгын бүтээн байгуулалтад зарцуулсан байна. Харин ирэх таван жилд үүнийг 10 дахин нэмэгдүүлж, 600-800 тэрбум ам.доллар буюу жилд 120-180 тэрбум ам.долларыг уг санаачилгын бүтээн байгуулалтад зарцуулна гэдгээ илэрхийлээд байна.

Тодруулбал, БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлтийн хорооны дэд дарга Нин Жие хоёр өдрийн турш үргэлжлэх уулзалтын үеэр олон улсын сэтгүүлчдэд өгсөн ярилцлагадаа энэ талаар дурьджээ. Тэрбээр “Нийтдээ 600-800 тэрбум ам.доллар зарцуулна. Энэ хөрөнгө оруулалт чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих дэлхийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь байх болно” гэжээ. 2013-2016 онд Хятад компаниуд “нэг бүс, нэг зам” дагуух улс орнуудад 60 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийснээр 180 гаруй мянган ажлын байр шинээр бий болсноос гадна орон нутгийн төсөвт 1.1 тэрбум ам.долларын татвар төлсөн байна.

## Венесуэлийн ахмадууд чулуу барин, Ерөнхийлөгчийнхөө эсрэг жагслаа

Газрын тосны арвин их нөөц баялагтай атлаа эдийн засгийн хямралд өртөөд буй Венесуэльд сүүлийн үед эсэргүүцлийн жагсаал удаа дараа зохион байгуулагдсаар байна. Жагсагчид нийслэл Каракас хотод галтай лонх, хүний өтгөн бүхий лонх зэргийг барин эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлж байгаа ч, тухай бүрт цагдаагийн алба хаагчид хүч хэрэглэн хүчээр зогсоож байгаа. Үүний улмаас хүний амь эрсэдсэн тохиолдол ч олон гарч байна. Тэгвэл үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор өнгөрөгч бямба гарагт Венесуэлийн ахмадууд гартаа чулуу барин жагсаал хийжээ. Цагдаа нар жагсагчдыг тараахын тулд нулимс асаруулагч хий цацсан бол үүний хариуд жагсагчид цагдаа нар руу чулуу нүүлгэж, эсэргүүцлээ илэрхийлэгчдийг хүндэтгэхийг шаардсан байна. Венесуэльд өргөн хэрэглээний бараа, үүний дотор хүнсний бүтээгдэхүүн, эм тарианы хомсдол үүсээд байгаа юм. Эрүүл мэндийн салбарын хямрал ахмадуудад хамгийн хүнд цохилт болж байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд тус улсад эх хүүхдийн эндэгдэл эрс нэмэгдсэнийг харуулсан тайлан мэдээг энэ долоо хоногийн эхээр нийтэлсэнтэй нь холбогдуулан Эрүүл мэндийн сайд Антониета Капоральг Ерөнхийлөгч Николас Мадуро огцруулжээ.

А.Капорал нь ердөө дөрвөн сарын өмнө сайдаар томилогдож байсан юм. “Би өөрийн ач зээ нар, улс орноо хамгаалахын төлөө өнөөдөр энд эсэргүүцлээ илэрхийлж байна” гэж тус улсын 78 настай иргэн Рафаел Колменерс ярьжээ. Эсэргүүцлийн жагсаалын үеэр “ахмадуудыг хүндэтгэ” гэж олон хүн хашгирч байжээ. Нийгмийн халамжийн олон хөтөлбөр хэрэгжүүлж байсан Ерөнхийлөгч Уго Чавес 2013 онд таалал төгссөнөөр Н.Мадуро тус улсын төрийн тэргүүн болсон юм. Үүний дараа дэлхийн зах зээлд нефтийн үнэ унасны улмаас Венесуэлийн засгийн газрын нефть экспортоос олох орлого эрс буурч, улмаар тус улс хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн сүү, эм тариа болон бусад өргөн хэрэглээний барааны хомсдолд орсон билээ. Олон улсын валютын сангийн таамаглаж байгаагаар, Венесуэльд инфляцийн төвшин энэ онд 700 хувиас давах төлөвтэй байна.

## Хойд Солонгос пуужин харважээ

БНСУ, Японы Засгийн газар Хойд Солонгос өчигдөр 05:28 цагийн үед баруун хойд хэсгийн Хамгён аймгаас төрөл нь үл мэдэгдэх пуужин харвасан тухай мэдээлжээ. Японы Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ёсихидэ Суга өчигдрийн хэвлэлийн бага хурлын үеэр “Пуужинг Хамгёны нутгаас зүүн хойд зүг чигт харвасан бөгөөд пуужин 30 минутад 800 км нисч, Солонгосын хойгоос зүүн тийш ойролцоогоор 400 км зайд Япон тэнгист унасан” хэмээн мэдэгджээ. Түүнчлэн, тус пуужин Японы эдийн засгийн бүсийн гадна унасан байна.

БНСУ-д ээлжит бус Ерөнхийлөгчийн сонгууль болж, Ардчилсан намаас нэр дэвшигч Мүн Жэ Ин ялалт байгуулан энэ сарын 10-нд тангаргаа өргөснөөс хойш Хойд Солонгос анх удаагаа пуужин харвасан нь энэ юм. Сонгуулийн кампанит ажлынхаа үеэр Хойд Солонгостой харилцах харилцааг шинэ төвшинд гаргаахаа амлаж, мөн тус улсад айлчлна гэдгээ илэрхийлсэн шинэ Ерөнхийлөгч Мүн Жэ Ин ч энэ удаагийн хэрэгт ихээхэн шүүмжлэлтэй хандаж буйгаа илэрхийлсэн байна. Пхеньян пуужин харвасантай холбоотойгоор Цагаан ордон ч мэдэгдэл хийж, тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээгээ чангатгахыг улс орнуудад уриалсан байна.

Хойд Солонгосын өчигдөр харвасан пуужингийн нэр төрлийг тодруулахаар эдүгээ мэргэжилтнүүд ажиллаж буй аж. Гэхдээ тив алгасагч пуужин биш гэдгийг мэргэжилтнүүд онцолж байна.

## Сая еврогийн титмийг музейгээс хулгайлжээ

Францын Лион хотын урлагийн музейгээс ойролцоогоор 1800 орчим ширхэг үнэт чулууугаар чимэглэсэн 19 дүгээр зууны үеийн хааны титэм хулгайлгагджээ. Энэ талаар Фурвьерын музейн удирдлагууд олон нийтэд мэдээлсэн байна. Тус музей руу энэ сарын 12-13-нд шилжих шөнө бүлэг хулгайчид өндөр технологийн хамгаалалтын системийг нь эвдэн нэвтэрчээ. Улмаар хамгийн үнэт, чухал урлагийн бүтээл болох Виржинийн хааны титэм, бөгж, хундаг тэргүүтнийг хулгайлан зүтгсэн байна.

Хулгайлагдсан хааны титмийг 1899 онд хийж байжээ. Тухайн үед Лионы бан чинээлэг эрхмүүдийн бэлэглэсэн үнэт чулуу, сувд гэх мэт 1791 ширхэг эрдэнэсээр чимэглэн урлаж байсан аж. Харин өнөөгийн ханшаар нэг сая гаруй еврогийн үнэ хүрэх гэнэ. Урлагийн музейн удирдлагууд титмийн үнэт чулууг өнгөрсөн жил судалж байсан судалгааны багийнхны бүхий л тооцоо, судалгааг хуулийнханд өгч, хулгайчийг илрүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй аж.

## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заагдсан дараах хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдана. Дуудлага худалдаа 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 10 цагт Аймгийн Засаг даргын тамгын газрын 315 тоот өрөөнд болно.

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар	Ашиглалтад орсон он	Худалдах доод үнэ /мян.төг/	Дэнчин /мян.төг/
1	Сүхбаатар аймаг Орон нутгийн өмчийн газар	Hyundai Bongo маркийн 51-14 CYA улсын дугаартай автомашин	-	5,000.00	1,250.0
2		Супер Бэни маркийн мотоцикл	2011	100.00	25.0
3		Супер Бэни маркийн A1416M902096 ардын дугаартай мотоцикл	-	100.00	25.0
4	Дарьганга сумын ЭМТ	Уаз 31512 маркийн 15-45 CYA улсын дугаартай автомашин	2008	1,000.00	250.0
5	Цагдаагийн газар	Зил 431418 маркийн 74-61 улсын дугаартай автомашин	2009	800.00	200.0
6		Шевролет маркийн 51-63 CYЭ улсын дугаартай автомашин	2009	500.00	125.0
7		Шевролет маркийн 51-53 CYЭ улсын дугаартай автомашин	2009	500.00	125.0
8		Уаз31512 маркийн 94-95 CYA улсын дугаартай автомашин	2008	1,000.00	250.0

### Дуудлага худалдаанд оролцох хүсэлт ирүүлэх:

- Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ 2017 оны 05 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 00 минутас өмнө аймгийн орон нутгийн өмчийн албанд ирүүлнэ.
- Дуудлага худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх /аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ /ний нотариатаар батлуулсан хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ. Бүрдүүлсэн баримтаа дутуунд хийж битүүмжлэсэн байна.

### Дуудлага худалдааны дэнчин:

- Худалдах доод үнийн 25%-тай гэнцэх тэнцэх төгрөгийг Төрийн сан банкин дах Төсөвт газрын өөрийн орлого-120000954 тоот дансанд төлсөн байна.
- Худалдах тээврийн хэрэгслийн талаархи мэдээлэл, дуудлага худалдааны журам, худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг аймгийн орон нутгийн өмчийн газар / Нутгийн удирдлагын ордны 312, 315 тоот өрөө /-аас ирж авна уу?
- Холбоо барих Утас 70510020,

СҮХБААТАР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр

1. Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь “Байгаль орчны экологи, эдийн засгийн хохирол тооцоох аргачлал хийж, дүгнэлт гаргах”-ийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 335,2 га талбай болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 12:00 цагаас 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 17:00 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн 12:00 цагийн дотор ирүүлнэ үү.

Налайх дүүрэг, 2-р хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас: 7023-2788

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 12-ний өдөр.

Тендер шалгаруулалтын нэр: Элэгний В, С вирус тоолох тоног төхөөрөмж нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: 2017-Б017

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендер оролцогчдоос: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Элэгний В, С вирус тоолох тоног төхөөрөмж” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000,0 (Гавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:  
- Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.  
- Түргэн хөрөөх чадвартай хөрөнгө болон авч боломжтой зээлийн нийт дүн: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна.  
- Сүүлийн 3 жилийн аль нэг жилийн хугацаанд тендер

санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээ, хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

**Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:**  
Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх  
Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.  
Тендерийн баталгааны дүн: 6,000,000 (Зургаан сая) төгрөг  
Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 14 цаг 00 минутас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байшгуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 14 цаг 30-минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.  
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг Нутгийн удирдлагын ордон 3-н давхар, Орон нутгийн өмчийн газар, 306 тоот өрөө(Ахлах мэргэжилтэн Ч.Багболд, Утас:70518123, 96510404)]

# ЗАВСАРЛАГА

ДУУЛГАХ СОНИН

## Сэлэнгийн шилмэл үндрийн мал, амьтдын үзэсгэлэн гарлаа

Б.ДАВАА

Сэлэнгэ аймгийн нутгийн удирдлагын ордны өмнөх партизаны талбайн урд хэсэгт төмөр сараалжин хашаануудыг байрлуулсан байх бөгөөд тэнд нүдэнд төдийлөн танил бус том биетэй үхэр, нарийн ноос бүхий хонь, янз бүрийн үүлдрийн нохой, цацагт хяруул зэрэг мал, амьтдыг байрлуулсан байх аж.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ, ХХААГ хамтран “Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгон хөгжүүлэх боломж” сэдэвт онол үйлдвэрлэлийн бага хурлыг зохион байгуулж, энэ хурээнд тус аймагт өсгөн, үржүүлж буй шилмэл үүлдрийн мал амьтдын үзэсгэлэнг гаргасан нь энэ юм.

Мөн Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүн болох хмелийн талх, эсгий урлал, төрөл бүрийн бордоо, тэжээл, эрүүл мэндийн цай тэргүүтний үзэсгэлэн худалдаа ч гарсан байв.

Шилмэл малын үзэсгэлэнд тус аймгийн Сүхбаатар, Цагааннуур, Зүүнбүрэн, Орхонтуул, Түшиг зэрэг нийт найман сумдын Алатау, Голштейн, Халимаг, Казахын цагаан толгойт, Хар тарлан, Геррефорд, улаан ангус, лимүзин, монбельярд үүлдрийн үхэр оролцсон бол суффоллик, ерөө, орхон үүлдрийн хонь, Сүхбаатар сумын шувуу үржүүлэгч Ж.Ганбаяр, Л.Машбат нарын боксер, бээжин нугас, бор нугас, хар нугас, брама, бүдэн, цацагт хяруул, тахиа галуу, нохой үржүүлэгч Н.Билэгтнاران, Б.Хүлэгүн нарын монгол банхар, түвд банхар, дундад ази үүлдрийн ноход ч байрлаж, сэлэнгчүүд хийгээд бага хуралд оролцохоор очсон олны нүдийг хужирлаж байлаа.



Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр 30  
Шөнө 11

Нөгөөдөр  
Өдөр 31  
Шөнө 13

### Өдрийн зурхай

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал: Сайн нөхөртэй нөхөрлөнө  
Наран ургах, шингэх:  
05.18-20.25



Аргын тооллын 5 сарын 15, Сутъяа гараг. Билгийн тооллын 19, Суулга одтой, хар бар өдөр. Өдрийн наран 5 цаг 18 минутад ланган, 20 цаг 25 минутад жаргана. Тухайн өдөр торь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эл, этнэлийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн талирыг сэргээх, харал, жатхыг буцаах, амьлуулах, өгдөөгийн тулээг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золлиг гаргах, болбын үйл, хүүхэд хөлд оруулахад туу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогдод баруун ураги мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирах” хэмээх сайн.

СОНИРХУУЛАХАД

## Жүжигчин Т.Бархүү ЦОМГОО ГАРГАНА

“Боловсрол” суваг телевизээс хоёр дахь жилдээ зохион байгуулж буй “Яг түүн шиг” шоууд тун амжилттай оролцож яваа нэгэн бол “Х түц” продакшны жүжигчин Т.Бархүү. Түүний авьяас чадварыг биширсэн шүтэн бишрэгчид нь фэйсбүүк, твиттер хуудаснаа “Яг түүн шиг шоу биш. Харин Т.Бархүүг барах уу гэдэг шоу юм биш үү” хэмээн жиргэцгээж буй.

Тэрбээр бусад оролцогчдоосоо илт давуу байж гурван удаагийн дугаарын ялагч болж тус бүр гурван сая төгрөгийн шагналын эзэн болсон. Тэгвэл авьяаслаг уран бүтээлч маань дуулах ур чадварынхаа талаар “Би хүүхэд байхаасаа л дуулах дуртай байлаа. Тиймээс ч Хүүхдийн ордны дуулаачийн дугуйланд суралцдаг байсан.

Жүжигчин хүн маш их авьяастай байх шаардлагатай. Дуулах бол наад захын асуудал. Би өөрийн цомгоо гаргана” хэмээн ярьжээ. Ямартай ч авьяаслаг уран бүтээлч маань шүтэн бишрэгчиддээ өөрийн шинэхэн цомгоороо бэлэг барих нь бололтой.



Бидэнд тохиолдсон

КҮНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД  
Ц.Орхонсэлэнгэ Увс



Саяхан манай ахынх бүл нэмээд охинтой болсон юм. Охины ах нь дөрвөн настай юм л даа. Тэгсэн аавдаа “Би танайхаас явлаа. Төөрлөө” гэж хэлсэн гэнэ. Ах “Яасан миний хүү” гэсэн чинь “Та нар дүүг миний бор охин гэж эрхлүүлчихээд намайг тоохгүй юм. Би танай хүүхдийг чинь зодно шүү” гэж сүрдүүлж. Аав нь “Ингэж болохгүй миний хүү. Унсье” гээд ойртголт өөдөөс нь “Битгий солиор” гэсэн гэнээ. Хаха энэ хүүхдүүд үү.

СУДЛААЧИЙН ҮГ

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН УРАМШУУЛЛЫН СИСТЕМИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ СУДЛАХ НЬ

Өмнө хэрэгжиж байсан татварын тэр дундаа НӨАТ-ын тогтолцоо нь хийдэл ихтэй, зарим томоохон компаниуд татвараас зугтах, жижиг, дунд компаниуд албан бус салбарт орох, компани жижигрүүлэх зэрэг далд эдийн засгийг нөхцөлдүүлсэн сөрөг асуудлууд үүссээр байсан. Энэхүү зөрчил, дутагдлыг багасгаж, нөгөө талаар татварын бааз суурийг өргөтгөх, татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын тэгш шударга байх зарчмыг хангах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (НӨАТУС) 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тэгвэл, өнөөдөр энэхүү НӨАТУС-ийн хэрэгжилт хэр хангагдаж байгаа, түүний үр дүн ямар байгааг хэмжих, судлан тогтоох судалгаа шинжилгээний ажил зайлшгүй чухал байна. НӨАТУС-ийг бий болгосноор татвараас зайлсхийх явдлыг иргэдийн оролцоотой хянаж бууруулах боломжтой болохыг цөөнгүй улс орнуудын туршлага харуулж байна. Хэрэглэгч худалдан авалтын баримт шаардвал татвараас зайлсхийх боломж аж ахуйн нэгж байгууллагда алга болно.


Иймээс нэмэгдсэн өртгийн албан татварын хэрэгжилтийн байдалд иргэдээс эмпирик судалгаа хийж гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнгээс харахад НӨАТУС-д дараах асуудлууд тулгарч байна гэж үзлээ.

- Техник технологийн хүрээнд: Цахим төлбөрийн системийг ашиглахад интернет орчин шаарддаг, ухаалаг гар утас шаардлагатай байдаг, баримт бүртгүүлэхэд цаг хугацаа шаарддаг.
- Иргэдийн боловсролын хүрээнд: Ахмад настай иргэд хэрэглэхэд хүндрэлтэй, олон иргэн дансны мэдээлэл, овог нэрээ үнэн зөв бүртгүүлэхгүйгээс НӨАТ-ын буцаалтыг олгож чадаагүй, ашиглах мэдлэг дутагцаас цахим системд бүртгүүлдэггүй, гэр бүл дундаа нэг бүртгэлтэй байдаг байна.
- Е-Баримтын чанарын хүрээнд: Цаасаар хэвлэсэн баримт урагддаг, хаягдаж гээгддэг, мартагддаг, бичиг, давтагдашгүй дугаар, сугалааны дугаар арилдаас бүртгэлд оруулж чадахгүй байх тохиолдлууд элбэг байдаг байна.
- Хамрах байдлын хүрээнд: Зах худалдааны төвүүд баримтаа өгдөггүй хэвээр байна. Энэ нь нөгөө талаас бага орлоготой худалдан авагч иргэдэд орлогод эзлэх нэмэгдсэн өртгийн албан татварын ачаалал өндөр байдагтай холбоотой юм. Эдгээр иргэд нэмэгдсэн

өртгийн албан татварын хоёр хувийн буцаалт авахаас илүүтэй нэмэгдсэн өртгийн албан татвар шингээгүй бага өртгөөр худалдан авалт хийх сонирхолтой байдгаас зах, худалдааны төвүүдээр үйлчлүүлэх хүсэлтэй байдаг байна.

• Эрсдлийн хүрээнд: Нэмэгдсэн өртгийн албан татварын баримт өгөхгүйгээр бараа үйлчилгээний үнийн дүнгээс хөнгөлөлт үзүүлэх санал тавих, худалдагч худалдан авалт тал хоорондоо харилцан тохиролцоо байдал гарч байна. Ингэснээр тайлан бүртгэлд баримтыг тусгахгүй нөхцөл бүрддэг. Иргэдийн хувьд энэ сонирхол өндөр байгаа нь танд НӨАТ-ын баримт өгөхгүйгээр бараа үйлчилгээний үнийн дүнгээс хөнгөлөлт үзүүлэх санал тавивал та зөвшөөрөх үү гэхэд 69.4 хувь нь зөвшөөрнө гэсэнээс харагдсан.

...Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд цаашид иргэдийг системд баримтаа бүртгүүлэх нэмэлт үйлдэл хийлгэхгүйгээр худалдан авалт нь бүртгэлийн системд шууд бүртгэгддэг болох, зах худалдааны төвүүдийг баримт олгуулах техник технологийн арга замгыг олж нэвтрүүлэх хэрэгтэй байна. Мөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалт нь худалдан авалт хийх бүрт иргэдийн дансанд нь шууд ордог байх, супер хонжвор болон



Зураг 1. НӨАТ-ын баримтгүй худалдан авалт хийх эрсдэл байгаа эсэх

хонжворт сугалааны их дүнг багасгаж хүрээг нэмэгдүүлэх, иргэдийг баримтаа шаардах нь иргэн хүний үүрэг, улс орноо эрүүлжүүлэх хөгжлийн төлөө хийж буй зүйл гэдгийг ойлгуулж таниулах шаардлагатай байна.

Мөн бусад улс орнуудын туршлагаас дараах зүйлсийг авч хэрэгжүүлж болох юм. Словак улсын шат дараалалтайгаар хонжворт сугалаа явуулдаг туршлагыг хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл эхний 20.0-4000.0 мянган төгрөг хүртэлх хонжворт бүх баримтнууд оролцдог бол, 20,000.0 болон 100,000.0 мянган төгрөгийн хонжвор, супер хонжворын шагналд 20.0 төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий баримтуудыг хамруулна гэх мэт. Ингэснээр өндөр дүнтэй баримтууд системд бүртгэгдэх нь нэмэгдэж, супер хонжворын эзэн тодрохгүй өнгөрөх

нь буурах бөгөөд баримт шаардах байдал өснө. Мөн Словак улсын муж бүрт бүртгэгдсэн худалдан авалтын баримтуудаас нэг ялагчийг тодруулдаг туршлагыг хэрэгжүүлэх, ингэснээр орон нутгийн иргэдийн идэвхи сайжирна.

Португаль улсын машины засвар үйлчилгээ, орон сууц, нийтийн хоолны үйлчилгээ, үсчин болон бусад гоо сайхны үйлчилгээнд төлсөн НӨАТ-ын 15 хувийг буцаан олгодог туршлагыг үндэслэн иргэдийн өдөр тутмын хэрэгцээнд зориулсан худалдан авалтанд төлсөн НӨАТ-ын буцаан олгогтын хувийг бусад бараа, үйлчилгээгээс ялгаатай өндөр тогтоож болно. Ингэснээр системд хамрагдахгүй байгаа хүнсний зах, худалдааны төвүүдээс иргэд онцгойлон баримтаа шаардах бөгөөд нөгөө талаар өдөр тутмын хэрэгцээнд буцаалтыг өндөр авснаар бага

орлоготой иргэдийн хувьд НӨАТ-ын ачаалал буурах болно.

Тайвань улс, Словак улсын туршлагаас харахад сар бүр, долоо хоног бүр хонжворт сугалааг явуулахдаа аль алинд нь өмнөх хоёр сарын баримтуудыг хамруулан тодруулдаг байна. Үүнийг үндэслэн манай улс мөн өмнөх хоёр сарын баримтуудыг хамруулбал илүү далайцтай болох юм. Эцэст нь нэмэгдсэн өртгийн албан татвар нь дэлхий даяар түгээмэл тархсан орчин үеийн санхүүгийн механизм бөгөөд байнга боловсронгуй болон хөгжсөөр байна. Энэ хөгжлийг даган Монгол Улсын НӨАТ-ын тогтолцоо ч мөн хөгжиж байгаа тул энэхүү сэдвийн хамрах цар хүрээ, судлагдахуун үүгээр хязгаарлагдахгүй юм.

СЭЗИС-ийн магистрант Х.ПИЛМАА